

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХҮЛЭЭН АВСАН КОМИССЫН АКТ

2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 02

Хатансуудал

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Гэрээний нэр, дугаар, огноо: 2023 оны 05 дүгээр сарын 26-ны өдрийн Баянхонгор аймгийн Баянлиг сум Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор фитнес төв байгуулах тоног төхөөрөмж нийлүүлэх захиалагч нийлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээ

2. Тоног төхөөрөмжийн нэр, хүчин чадал: 15 төрлийн тоног төхөөрөмж

3. Захиалагч байгууллага **Баянлиг сумын Засаг даргын тамгын газар**

4. Гүйцэтгэгч байгууллага **А.Батцэнгэл захиралтай "Санаа мед трейд" ХХК**

5. Засаг даргын 2023 оны 06 сарын 30-ны өдрийн А/91 тоот захирамжаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор фитнес төв байгуулах тоног төхөөрөмж хүлээн авах комисс нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан БХАБЛСЗДТГ/202312004 тоот гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг гэрээний хавсралт, техникийн тодорхойлолт, ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг хангасан байдал, барааны чанар, тээвэрлэлт, хадгалалтын байдал болон тоног төхөөрөмжийн холбогдох баримтуудтай газар дээр нь танилцан шалгав.

6. Гүйцэтгэгч нь фитнес төв байгуулах тоног төхөөрөмжийг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр гэрээнд заасны дагуу бүрэн нийлүүлж дууссан байна.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

1. Тоног төхөөрөмжийг шалгаж үзээд 7,5кг-тай 8 ширхэг диск болон гантель үйлдвэрлэх боломжгүй болсон тул 10кг-ын 4 ширхэг, 5кг-ын 4 ширхэг диск, гантелийг тус тус орлуулан нийт 200 кг болон ирсэн. . Эдгээрийг ажлын хэсэг ярилцан энэ хэвээр хүлээн авахаар шийдвэрлэв. Мөн ажил гүйцэтгэх хугацаанд 1 ширхэг толь 25см орчим цуурсныг тухайн гүйцэтгэгч компани цууралт нөхөгч ирүүлэхээр болсон. Толины шрупны толгой дарагч 20 ширхэг, штангийн тахир гол 1 ширхэг, штангийн шулуун гол төмөр 2 ширхэг ирээгүй ба Улаанбаатар хотоос гарах том тэрэгний жолоочид хүлээлгэн өгч баталгаажсны дараа санхүүжилтийг шийдвэрлэхээр тохиролцов. Техникийн тодорхойлолт бэлтгэхдээ хөлийн 2 толгойт төхөөрөмж гэж тодорхойлсон байна. Ирсэн төхөөрөмж хөлийн 4 толгойт төхөөрөмж байсан. Иймд тухайн төхөөрөмж

сайжиран ирсэн тул энэ хэвээр хүлээн авч гүйцэтгэгч байгууллага гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн гэж дүгнэв.

2.Тоног төхөөрөмжийг захиалагч байгууллагын мэдэлд бүрэн шилжүүлж, ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

3.Тоног төхөөрөмж хүлээн авах комиссын акт, холбогдох баримт бичиг, материалыг 4 эх хувь үйлдэж, захиалагч, гүйцэтгэгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус бүрт нэг хувийг хүргүүлнэ.

4.Энэ актаар хүлээн авсан тоног төхөөрөмжийн баримт бичгийн иж бүрдэл нь дараахаас бүрдэнэ. Үүнд:

- а)Тоног төхөөрөмжийг дагалдах техникийн бусад баримт бичиг: Техникийн тодорхойлолт
- б)Баталгаат засварын хугацаа, холбогдох баримт: Баталгаат хугацаа
- в)Бусад: Зарлагын баримт

ГУРАВ.ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Нэр төрөл	Үйлдвэрлэсэн улс, байгууллага, огноо	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ, ₮	Нэр төрөл бүрийн нийт үнэ, ₮	Тээвэрлэлт, угсралтын үнэ болон бусад үйлчилгээний үнэ, ₮	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж, ₮	Нэр төрөл бүрийн нийт үнэ, ₮ (7+8+9)	Монгол улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Мөрний төхөөрөмж	БНХАУ	ш	1	3,827,000	3,827,000	43,000	430,000	4,300,000	Үгүй
2	Цээжний хэвтээ шахалтын төхөөрөмж		ш	1	1,513,000	1,513,000	17,000	170,000	1,700,000	Үгүй
3	Гүйлтийн зам		ш	2	6,675,000	13,350,000	150,000	1,500,000	15,000,000	Үгүй
4	Спиннинг дугуй		ш	2	1,424,000	2,848,000	32,000	320,000	3,200,000	Үгүй
5	Хэвлийн вандан		ш	2	801,000	1,602,000	18,000	180,000	1,800,000	Үгүй
6	Хөлийн 4 толгойт төхөөрөмж		ш	1	2,572,100	2,572,100	28,900	289,000	2,890,000	Үгүй
7	Олон үйлдэлт төхөөрөмж		ш	1	8,544,000	8,544,000	96,000	960,000	9,600,000	Үгүй
8	Диск 200кг		ш	1	2,670,000	2,670,000	30,000	300,000	3,000,000	Үгүй
9	Гантель 200кг		ш	1	2,937,000	2,937,000	33,000	330,000	3,300,000	Үгүй
10	Гантелийн тавиур		ш	1	1,068,000	1,068,000	12,000	120,000	1,200,000	Үгүй
11	Штангийн тахир гол		ш	1	160,200	160,200	1,800	18,000	180,000	Үгүй
12	Штангийн шулуун урт гол		ш	2	222,500	445,000	5,000	50,000	500,000	Үгүй
13	Толь 2*3		ш	5	320,400	1,602,000	18,000	180,000	1,800,000	Үгүй
14	Фитнесийн шал		м ²	20	89,000	1,780,000	20,000	200,000	2,000,000	Үгүй
15	Сандап		ш	2	1,068,000	2,136,000	24,000	240,000	2,400,000	Үгүй
Нийт үнийн дүн, ₮ /Тавин хоёр сая найман зуун далан мянган/ төгрөг									52,870,000	

**“НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ФИТНЕС ТӨВ
БАЙГУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” ХҮЛЭЭН АВСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2023оны 7 дугаар сарын 03-ны өдөр

Хатансуудал

Баянлиг сумын Засаг даргын 2023-оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/91 тоот захирамжаар батлагдсан ажлын хэсэг буюу ажлын хэсгийн ахлагч Засаг даргын Тамгын газрын дарга Г.Мөнхсүх, гишүүд 5 дугаар багийн Засаг дарга Б.Амаржаргал, Хоршоо хөгжүүлэх сангийн мэргэжилтэн А.Гантулга, Архив, бичиг хэргийн эрхлэгч Д.Тогмид, сан хариуцсан Нягтлан бодогч С.Бадамсүрэн нарын бүрэлдэхүүнтэй тендерээр шалгарсан “Санаа Мед Трейд” ХХК-ний нийлүүлж буй тоног төхөөрөмжүүдийг хүлээн авлаа.

Тус тоног төхөөрөмж нь нийт 52,870,000(Тавин хоёр сая найман зуун далан мянган) төгрөгөөр нийлүүлэгдэж байгаа. Тоног төхөөрөмжүүдийг захиалагч, нийлүүлэгчийн хийсэн гэрээ, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авлаа.

Тоног төхөөрөмжүүдийг хүлээн авахад 7,5кг-тай 8 ширхэг диск болон гантель үйлдвэрлэх боломжгүй болсон тул 10кг-ын 4 ширхэг, 5кг-ын 4 ширхэг диск, гантелийг тус тус орлуулан нийт 200 кг болон ирсэн. . Эдгээрийг ажлын хэсэг ярилцан энэ хэвээр хүлээн авахаар шийдвэрлэв. Мөн ажил гүйцэтгэх хугацаанд 1 ширхэг толь 25см орчим цуурсныг тухайн гүйцэтгэгч компани цууралт нөхөгч ирүүлэхээр болсон. Толины шрупны толгой дарагч 20 ширхэг, штангийн тахир гол 1 ширхэг, штангийн шулуун гол төмөр 2ширхэг ирээгүй ба Улаанбаатар хотоос гарах том тэрэгний жолоочид хүлээлгэн өгч баталгаажсны дараа санхүүжилтийг шийдвэрлэхээр тохиролцов. Техникийн тодорхойлолт бэлтгэхдээ хөлийн 2 толгойт төхөөрөмж гэж тодорхойлсон байна. Ирсэн төхөөрөмж хөлийн 4 толгойт төхөөрөмж байна. Тухайн төхөөрөмж сайжиран ирсэн тул энэ хэвээр хүлээж авлаа. Тус нийлүүлэгч компанийн зүгээс Засаг даргын Тамгын газарт чанга яригч буюу спикер бэлэглэсэн.

Ийнхүү тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын зураг нэршилтэй тулган хүлээн аваад, ажлын хэсэг яаж ашиглах зөвлөгөө авч зургаар баталгаажуулав.